

ЦАХИМ ХУВААГДАЛ

ТЕХНОЛОГИ, ТЭГШ БУС БАЙДАЛ БА ХҮНИЙ ЭРХ



ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА	4
2. ТЕХНОЛОГИОС ХАМААРАЛТАЙ ТЭГШ БУС БАЙДАЛ БА ХҮНИЙ ЭРХ	7
3. ТЭГШ БУС БАЙДАЛ БА ТЕХНОЛОГИ: НЭГ ЗООСНЫ ХОЁР ТАЛ	9
4. ТЕХНОЛОГИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ АЛХАМ	12
5. ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХГҮЙ ТЭГШ БАЙХ ЭРХ	13
5.1 Тохиолдол судлал: «Үзэн ядагч» машин	16
5.2 Тохиолдол судлал: Царай таних технологи	17
6. ХӨДӨЛМӨРИЙН АЯТАЙ НӨХЦЛӨӨР ХАНГУУЛАХ ЭРХ	18
6.1 Тохиолдол судлал: Гэрээт ажлын байрны зах зээл	21
6.2 Тохиолдол судлал: Технологийн салбарын «Сүүдэр ажилчид»	22
6.3 Тохиолдол судлал: Том технологийн агуулга сайжруулагчид	23
7. ДҮГНЭЛТ: ТЕХНОЛОГИЙН ТЭГШ БАЙДАЛ ХАНГАХЫН ТӨЛӨӨ	26

**ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ ХҮН БҮРД ЭРХИЙГ НЬ ЭДЛҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ
ХҮМҮҮСИЙН ХҮНЛЭГ СЭТГЭЛД ТУЛГУУРЛАН КАМПАНИТ АЖИЛ ӨРНҮҮЛДЭГ
10 САЯ ХҮНИЙГ ЭГНЭЭНДЭЭ НЭГТГЭСЭН ДЭЛХИЙ ДАЯАРХ ХҮНИЙ ЭРХ
ХАМГААЛАГЧДЫН ХӨДӨЛГӨӨН ЮМ.**

**ЭРХ БАРИГЧИД ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ, ХЭМ ХЭМЖЭЭГ ХҮНДЭТГЭДЭГ,
ХАРИУЦЛАГАА ХҮЛЭЭДЭГ, АМЛАЛТДАА ХҮРДЭГ ДЭЛХИЙ ЕРТӨНЦИЙГ
БИЙ БОЛГОХЫН ТӨЛӨӨ БИД АЖИЛЛАДАГ.**

**БИД АЛИВАА ЗАСГИЙН ГАЗАР, УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ СУРТАЛ, ЭДИЙН ЗАСГИЙН
АШИГ СОНИРХОЛ, ШАШИН ШҮТЛЭГЭЭС АНГИД БИЕ ДААСАН, ХАРААТ БҮС
БӨГӨӨД ГИШҮҮД ДЭМЖИГЧДИЙНХЭЭ ХАНДИВ ТУСЛАМЖААР САНХҮҮЖДЭГ.**

**ХҮМҮҮС ЭВ САНААНЫ НЭГДЭЛТЭЙ, ХҮМҮҮНЛЭГ ЭНЭРЭНГҮЙ БАЙСНААР
ИЛҮҮ САЙХАН НИЙГМИЙГ БИЙ БОЛГОЖ, ӨӨРЧИЛЖ ЧАДНА ГЭДЭГТ БИД
ИТГЭДЭГ.**

©Эмнести Интернэшнл 2023 он.

Энэ товхимол дахь контент нь Креатив Коммонс-оор зөвшөөрөгдсөн
(жинхэнэ эх хувь, худалдааны бус, хуулбарлаагүй, олон улсын 4.0)
лицензийн дагуу баталгаажсан болно.

<https://creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode>

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл манай: www.amnesty.org
цахим хуудасны зөвшөөрөл хэсгээр зочлоорой.

©Эмнести Интернэшнл 2023

Peter Benenson House, 1 Easton Street, London
WC1X 0DW, UK

Индекс: АСТ 10/7246/2023

Эх хэл: Англи

amnesty.org

amnesty.mn



1. ТАНИЛЦУУЛГА

Дэлхий даяар өргөнөөр ашиглагдаж буй цахим технологи нь эдийн засаг, засаглал, нийгмийн тэнцвэрийг бүрмөсөн өөрчилсөн. Өнөөдөр дэлхийн хүн амын талаас илүү хувь нь мэдээ мэдээлэл авах, хоорондоо харилцах, ажиллах, сурч боловсрох зорилгоор цахим сүлжээг ашиглаж байна.¹ Цахим технологи нь 4 тэрбум гаруй хүний хувьд нийгмийн байр сууриа баталгаажуулах, олон төрлийн эрхээ эдлэх суурь болж байна.² Үүнийг ядуурлын эсрэг тэмцэлд гарсан хамгийн том ухралт буюу 93 сая хүнийг нэн ядуурал руу түлхэн оруулах үндсэн шалтгаан Ковид-19 цар тахлын эхэн үеийн нөхцөл байдлаас харж болно.³

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) болон хүний эрхийн бусад байгууллагууд технологийн ач холбогдлыг хүний эрхийг сурталчлан таниулах, хамгаалах, хэрэгжүүлэх хэрэгсэл гэж тодорхойлсон ч чухамдаа технологи нь “хүний эрхийг, ялангуяа нийгмийн цөөнх эсвэл ялгаварлан гадуурхагдсан хүмүүсийн эрхийг зөрчихөд ашиглагдаж байна”.⁴

Зохицуулалт сул байгаагаас цахим технологи нь нийгэм, арьсны өнгө, үндэс, эдийн засгийн тэгш бус байдлыг

улам гааруулан хурцатгаж, бүтцийн мөлжлөгийг гүнзгийрүүлдэг болох нь улам бүр тодорхой боллоо.

Технологи хоосон орон зайд дангаар ажиллахгүй, технологийн хөгжлийн үргэлжилсэн давалгаанууд нь газар зүйн онцлог, улс төр, хэлний дархлаа зэрэг хүний амьдрах нөхцөлд шууд нөлөө үзүүлж байгааг хүний эрх хамгаалагчид, нийгмийн бүлгүүд ажиглажээ. Гэвч бодлого боловсруулагчид, технологийн компаниуд эдгээр нөхцөл байдал, үзэл бодлын ялгаа, амьдралын хэвшлийг анхаарч үзэхгүй байна.⁵

Эмнести Интернэшнл болон бусад хүний эрхийн байгууллагууд нь технологийн аварга тандагчид, тэдний бүтээсэн загварчлал хүний эрхийг зөрчих, өөрөөр сэтгэгчдийг нухчин дарах,⁶ тэгш бус байдлыг улам хурцатгах, тандалтыг хэвийн мэт харагдуулах, улс төрийн албадлагыг өөгшүүлж байгааг баримтжуулсан.⁷ Технологийн шинэ хэлбэрүүд нийгмийн амьдралд илүүтэй нөлөөлж байгаад улам их анхаарал хандуулах шаардлагатай.

Олон салбарт цахим бүтээгдэхүүний гүйцэтгэх үүрэг улам нэмэгдэж цахим орчин тэлж байгаа болхоор технологиос эрхээ хамгаалж, эрхээ эдлэхэд өнөөдөр төдийгүй ирээдүйд чухлаар нөлөөлнө.

¹ Amnesty International, *Surveillance giants: How the business model of Google and Facebook threatens human rights* (Index: POL 30/1404/2019).

² Amnesty International, *Surveillance giants: How the business model of Google and Facebook threatens human rights* (Index: POL 30/1404/2019). pg. 5.

³ Amnesty International, *Rising Prices, growing protests: the case for universal social protection* (Index: POL 40/6589/2023).

⁴ Report of the United Nations High Commissioner for Human Rights: The right to privacy in the digital age, UN Doc A/HRC/48/3, pg. 2 para. 4.

⁵ Road map for digital cooperation: implementation of the recommendations of the High-level Panel on Digital Cooperation Report of the Secretary-General. UN Doc. A/74/821.

⁶ Report of the United Nations High Commissioner for Human Rights: The right to privacy in the digital age, UN Doc A/HRC/48/3, pg. 2 pg. 3.

⁷ Amnesty International, *Surveillance giants: How the business model of Google and Facebook threatens human rights* (Index: POL 30/1404/2019);

Amnesty International, **Myanmar**: *The social atrocity: Meta and the right to remedy for the Rohingya* (Index: ASA 16/5933/2022).

ТЕХНОЛОГИЙН ХӨГЖИЛ ХҮМҮҮС, НИЙГМИЙН БҮЛГҮҮДЭД ЭРХЭЭ ХЭРХЭН ХАМГААЛЖ, ЭДЛЭХ ЁСТОЙГ ОЙЛГУУЛАХАД ЧУХАЛ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭНЭ.

Эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдал хурцадсан өнөөгийн нийгэмд технологи хийгээд тэгш бус байдал (эдийн засаг, арьсны өнгө, жендэр, хөгжлийн бэрхшээлтэй байдал, хэлний дархлаа) хэрхэн хоорондоо хамааралтайг мэдэхийг хүсэж буй хүмүүст зориулж энэхүү тайланг гарын авлага болгон гаргав.⁸

Түүнчлэн хүмүүсийн амьдралын олон салбар цахимжиж байгаа нь дэлхий даяарх хүний эрхийн төлөөх тэмцлийн талбар гэдгийг Эмнести Интернэшнлийн технологийн талаарх ажил харуулах болно.

Энэхүү ерөнхий тойм нь технологи хийгээд тэгш бус байдал огтлолцох үед гарах хүний эрхийн асуудлаар бодлого боловсруулагчид, олон нийт, оролцогч талуудад туслах бодлогын үндсэн баримт бичиг юм. Энд дурдагдсан асуудлууд бүрэн шийдэгдсэн гэсэн үг биш бөгөөд гол нь өсөн нэмэгдэж буй технологийн сөрөг талыг дэлхий нийтээр хэлэлцэх эхлэлийг тавихад оршино.

Эмнести Интернэшнлийн технологи, хүний эрхийн чиглэлийн дөрвөн зорилтын эхнийх нь энэ тайлан бөгөөд гаарч буй тэгш бус байдлын хямралтай тэмцэх идэвхтнүүд, нөлөөлөлд өртөгсөд, олон нийт, иргэний нийгэм, хүний эрхийн байгууллага, технологийн компани, бусад оролцогч талуудад эх сурвалж болгох зорилготой.

⁸ Amnesty International, *Rising Prices, growing protests: the case for universal social protection* (Index: POL 40/6589/2023).

2. ТЕХНОЛОГИОС ХАМААРАЛТАЙ ТЭГШ БУС БАЙДАЛ БА ХҮНИЙ ЭРХ

Хурдацтай хөгжиж буй технологийн шинэчлэлийн өнөө үед хүний эрх хамгаалагчид, бодлого боловсруулагчид технологитой холбоотой хор хөнөөлийг арилгахаар тэмцэж байна. Гэхдээ энэ тэмцэлд нэгдсэн ойлголттой байх нь чухал. Шинээр гарч ирсэн технологийн талаар нэгдсэн ойлголтгүй байгаа нь технологид суурилсан тэгш бус байдал цэцэглэх нөхцөл бүрдүүлж байна.⁹

Өнөөгийн цахим технологиуд нь хүний хувийн мэдээллийг ангилах, боловсруулахад ашигладаг хуучин систем дээр суурилж хийгдсэн бөгөөд урьд өмнө байсан тогтолцооны үргэлжлэл гэж хэлж болно.¹⁰

Цаашилбал, мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ) нь хүний хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, цаашлаад хувь хүн эсвэл ижил төстэй бүлэг хүмүүст нөлөөлдөг нь цахимчлалаас өмнө ч хүний эрхийн байгууллагуудын анхаарлын төвд байсан.¹¹

ЭНЭ ТАЙЛАНД ТЕХНОЛОГИ ГЭДЭГТ БҮХ ТӨРЛИЙН ДАТА МЭДЭЭЛЭЛ ТҮҮНИЙ СҮЛЖЭЭ, СҮЛЖЭЭНИЙ ТӨХӨӨРӨМЖ, АЛГОРИТМЫН СИСТЕМҮҮДИЙГ БАГТААСАН.

Хувийн корпорациудын бүтээсэн эдгээр хэрэгсэл, системүүдийн ихэнх бизнесийн загвар, бүтэц нь ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор мэдээллийг авах, хадгалахад зориулагдсан байдаг.¹² Эрүүл мэнд, нийгмийн халамж, боловсрол, олон нийтийн аюулгүй байдал, ажлын байр зэрэг технологид суурилсан хувь хүний болон нийгмийн амьдралын хэд хэдэн салбарт “мэдээлэлжүүлэлт” гэсэн нэрээр хүний эрхийг зөрчдөг.¹³

⁹ See: Meredith Broussard, *Artificial Unintelligence: How Computers Misunderstand the World*, 2018; Tressie MacMillam Cottom, “Where Platform Capitalism and Racial Capitalism Meet: The Sociology of Race and Racism in Digital Society” *Sociology of Race and Ethnicity* (2020); David Noble, *Forces of Production: A Social History of Industrial Automation*, 2011.

¹⁰ See: Virginia Eubanks, *Automating Inequality: How High-Tech Tools Profile, Police, and Punish the Poor*, 2018 and Ruha Benjamin, *Race After Technology: Abolitionist Tools for the New Jim Code*, Polity Press (2019).

¹¹ See: Edwin Black, *IBM and the Holocaust: The Strategic Alliance between Nazi Germany and America's Most Powerful Corporation*, 2001.

¹² See: Amnesty International, *Surveillance giants: How the business model of Google and Facebook threatens human rights* (Index: POL 30/1404/2019); Shoshana Zuboff, *The Age of Surveillance Capitalism: The Fight for a Human Future at the New Frontier of Power*, 2018 (Zuboff, 2018)

¹³ Kenneth Neil Cukier and Viktor Mayer-Schoenberger, *The Rise of Big Data: How It's Changing the Way We Think About the World*, Foreign Affairs, May/June 2013, <https://www.foreignaffairs.com/articles/2013-04-03/rise-big-data>.

Эмнести Интернэшнл, бусад байгууллагын өмнөх судалгаанууд дээр үндэслэсэн энэхүү тайлан нь тэгш бус байдалд хамгийн их эрсдэл учруулах хоорондоо холбоотой байх магадлалтай дараах технологиудад анхаарлаа хандууллаа.

МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ПЛАТФОРМ БОЛОН ТӨХӨӨРӨМЖ

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг оролцуулаад цахим сүлжээнд холбогдсон мэдээлэл солилцох платформ, төхөөрөмжүүд;

АЛГОРИТМЫН СИСТЕМ БОЛОН ШИЙДВЭР ГАРГАХАД АШИГЛАХ ХЭРЭГСЭЛ

Шийдвэр гаргах үйл явцад ашиглах хэрэгсэл нь ихэнхдээ хүний оролцоогүйгээр, математик тооцоолол, зааварчилгаанд үндэслэж асуултын хариултыг тооцоолон гаргадаг алгоритмын систем, бие дааж шийдвэр гаргадаг хэрэгслүүд;¹⁴

ХЯНАЛТ, ТАНДАЛТЫН БОЛОН ХУУЛЬ САХИУЛАХ ТЕХНОЛОГИ

Төр, хувийн хэвшлийн байгууллагуудын ашигладаг хяналт, тандалтын болон хууль сахиулах технологи нь ихэвчлэн хүнд өөрт нь мэдэгдэлгүйгээр, ямар ч зөвшөөрөлгүйгээр тухайн хүний зан үйлдлийг хянах, удирдах зорилгоор зохион бүтээгдсэн байдаг.¹⁵

¹⁴ Amnesty International, *Xenophobic machines: discrimination through unregulated use of algorithms in the Dutch childcare benefits scandal* (Index: EUR 35/4686/2021), pg. 4.

¹⁵ Amnesty International, *Automated apartheid: how facial recognition fragments, segregates, and controls Palestinians in the OPT* (Index: MDE 15/6701/2023).

3. ТЭГШ БУС БАЙДАЛ БА ТЕХНОЛОГИ: НЭГ ЗООСНЫ ХОЁР ТАЛ

Сүүлийн хэдэн арван жилд дэлхий даяар баялгийн тэгш бус хуваарилалт нь урьд өмнөхөөс ихсэж, дэлхийн хамгийн ядуу хэсэг дэлхийн нийт баялгийн дөнгөж 2 хувийг, дэлхийн хамгийн баян хүмүүс 76 хувийг эзэмшиж байна.¹⁶ Үүний үр дүнд дэлхий даяар хүний эрхийн зөрчлийн гол хөдөлгөгч хүчин зүйл болох ядуурал хурдацтайгаар нэмэгдэж,¹⁷ аливаа засаглал ядуурлыг гэмт хэрэг гэж үзэх нь улам бүр өсчээ.¹⁸

Бүтцийн тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн Эмнести Интернэшнл, бусад хүний эрхийн байгууллагын хүчин чармайлт нь түүхэн болон материаллаг үндсэн шалтгаан болох колоничлолын системийн дарангуйлал, эдийн засгийн мөлжлөгийг арилгахад чиглэх ёстой.¹⁹ Ингэхдээ ялгаварлан гадуурхалтын янз бүрийн хэлбэр нь (арьс өнгө, жендэр, нийгэм эдийн засаг, хөгжлийн бэрхшээлтэй байдал гэх мэт хэлбэрүүд) нэгнээсээ тусдаа биш харин ч харилцан нөлөөллөөрөө нөхцөл байдлыг улам муутгаж байгааг харгалзан үзвэл зохино.

**ДЭЛХИЙН ХАМГИЙН ЯДУУ
ХҮН АМ НИЙТ БАЯЛГИЙН
ДӨНГӨЖ 2 ХУВИЙГ,
ХАМГИЙН БАЯН ХҮН АМ
76 ХУВИЙГ ЭЗЭМШИЖ
БАЙНА**

Технологиос үүдсэн зарим шинэ нөхцөл байдал харилцан хамааралтай алагчлалыг улам бүр өдөөхийн зэрэгцээ цахим ертөнцийн гаднах тэгш бус байдлыг ч улам гааруулж байна.²⁰

Дэлхийн өнөөгийн тэгш бус байдлын хямрал нь олонхийн хэрэгцээг биш эрх мэдэлтэй хүмүүсийн эрх ашгийг зориуд нэн тэргүүнд тавьсан олон арван жилийн бодлогын үр дүн бөгөөд технологийн салбар тэнцвэргүй байдлыг улам бүр нэмэгдүүлж байна.

¹⁶ Amnesty International, *Promotion of Inclusive and Effective Tax Cooperation at the United Nations Submission to the UN Secretary General, 78th General Assembly Session*, 5-19 September 2023 (Index: IOR40/6565/2023).

¹⁷ Adam Ploszka, "All Beginnings Are Difficult: The Guiding Principles on Extreme Poverty and Human Rights a Decade After Their Adoption," *Human Rights Law Review*, Volume 23, Issue 2, June 2023.

¹⁸ Peter Edelman, *Not A Crime to Be Poor: The Criminalization of Poverty in America*, The New Press (2019); Alex S. Vitale, *The End of Policing*, Verso Press (2017); Virginia Eubanks, *Automating Inequality: How High-Tech Tools Profile, Police, and Punish the Poor*, St. Martin's Press (2018).

¹⁹ UN Special Rapporteur on contemporary forms of racism, *Report: Ecological Crisis, Climate Justice and Racial Justice*, 25 October 2022, UN Doc. A/77/549, para. 1-2.

²⁰ Amnesty International, *Taxation, illicit financial flows and human rights* (Index: IOR 40/5771/2022).

Энэхүү тэнцвэргүй байдал нь саяхныг хүртэл арьсны өнгө, үндэс угсаа, жендэр, хөгжлийн бэрхшээлтэй болон орлогын тэгш бус байдал зэрэг “колоницлолын үед үүссэн арьс өнгөөр ялгаварлан гадуурхах эдийн засгийн мөлжлөг” дарангуйллын тогтолцоотой шууд хамааралтай.²¹ Ерөнхийдөө тэгш бус байдал нь жендэр, нийгэм эдийн засаг, хөгжлийн бэрхшээл, арьсны өнгө зэрэг хаа сайгүй тохиолдолд илэрч байна.²²

Эдгээр ялгаварлан гадуурхалт нь иргэний болон улс төрийн эрх (үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хувийн нууцтай байх эрх) төдийгүй эдийн засаг, нийгэм соёлын эрх (нийгмийн хамгааллын эрх, шаардлагад нийцсэн орон байртай байх эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрх)-ийг зөрчсөөр байгааг анхаарах ёстой.²³

ТЭГШ БУС БАЙДАЛ БА ХҮНИЙ ЭРХ

Технологиос хамааралтай өнөөгийн тэгш бус байдал нь ялгаварлан гадуурхалтаас ангид технологи эсвэл мэдээллийн удирдлагын систем бүтээгдэх боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрөхөд хүргэж байна. Учир нь бүтээсэн хүмүүсийн үзэл бодол, ертөнцийг үзэх үзэл, мөн бүтээх цаг үеийн улс төр, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал технологид үргэлж туссан байдаг. Мөн тэд тухайн үйл ажиллагаа явуулж буй орчноос хараат бус байж чаддаггүй. Өгөгдөл эсвэл алгоритмд суурилсан мэдээллийн удирдлагын систем, ялангуяа хайлтын системүүд ихэнхдээ хэл, соёл, арьс өнгө, үндэс, аюулгүй байдал, эдийн засгийн давуу эрхтэй олонхийн ашиг сонирхол, хэтийн зорилго ертөнцийг үзэх үзлийг тусгасан байдаг.²⁴

Технологийн тэгш байдлыг хангахад технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэгч компаниудын санхүү, эрх мэдлийн далд зорилгыг ил тод болгох ёстой. Эрдэмтдийн “техношовинизм”²⁵ ба “цахим колоницлол”²⁶ гэсэн тодорхойлолт нь өнөөдөр голчлон Хойд Америкт төвлөрсөн цөөхөн хэдэн технологийн компаниуд, тэдгээрийн санхүүжүүлэгчид ил тод бус систем ашиглаж, удирдаж, ашиг олж байгаа нь нийгмийн тэгш бус байдлыг өгүүлж байгаа юм. Эдгээр технологи нь олон тэрбум хүний ялангуяа тухайн бүтээгдэхүүнийг ашиглахаас өөр ямар ч сонголтгүй, аргагүй нийгмийн гадуурхагдсан бүлэг хүмүүсийн өдөр тутмын амьдралд асар их нөлөө үзүүлж байна.²⁷

21 UN Special Rapporteur on contemporary forms of racism, *Report: Global Extractivism and Racial Equality, Tendaye Achiume*, UN Doc. A/HRC/41/5414, pg. 7. For further and more detailed reading on the intersection of technology, race, and inequality: Ruha Benjamin, *Race After Technology: Abolitionist Tools for the New Jim Code*, Polity (2019); Virginia Eubanks, *Automating Inequality: How High-Tech Tools Profile, Police, and Punish the Poor*, St. Martin's Press (2018); Safiya Umoja Noble, *Algorithms of Oppression: How Search Engines Reinforce Racism*, NYU Press (2018).

22 World Inequality Lab, *World Inequality Report 2022*, <https://wir2022.wid.world>.

23 Michelle Gilman, *Data & Society*, “Expanding Frameworks: An economic justice approach to digital privacy,” November 6, 2019.

24 Safiya Umoja Noble, *Algorithms of Oppression: How Search Engines Reinforce Racism*, NYU Press (2018).

25 Meredith Broussard, *Artificial Unintelligence: How Computers Misunderstand the World*, MIT Press (2019).

26 Abeba Birhane, “Algorithmic Colonization of Africa” (2020) 17:2 *SCRIPTed: A Journal of Law, Technology, & Society*, <https://script-ed.org/?p=3888>.

27 Data & Society, *Tech Colonialism Today: Sareeta Amrute's keynote talk at EPIC2019*, 2019, <https://points.datasociety.net/tech-colonialism-today-9633a9cb00ad>.

НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨН НИЙГМИЙН БҮЛГҮҮД

Ноцтой хохирол учруулж болзошгүй технологийн шинэ хэлбэр, цахим хэрэгслүүдээ хамгийн түрүүнд орхигдсон, дарлагдсан эсвэл хамгаалалт султай бүлгүүдийн хүмүүс дээр туршдаг.²⁸ Ихэнхи тохиолдолд эдгээр бүлэг технологи, цахим системээс хэт хамааралтай байна.

Энэ тайланд дараах бүлгүүдийг авч үзнэ:

- Хууль эрх зүйн тогтсон статусгүй буюу дүрвэгсэд, харьяалалгүй иргэд, албадан нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүс;
- Системтэйгээр ялгаварлагдсан хохирогчид, тэр дундаа өнгөт арьстан, уугуул иргэд, бусад арьсны өнгөөр ялгаварлан гадуурхагдсан үндэсний цөөнх эсхүл гарал угсаагаараа хавчлагад өртсөн бүлгүүд;
- Ядуу, эдийн засгийн чадамжгүй хүмүүс, түүний дотор орон гэргүй эсвэл төрийн халамж, нийгмийн хамгааллын үйлчилгээг авдаг бусад бүлэг;
- Хоригдол эсвэл шоронгоос суллагдсан хүмүүс, тэр дундаа шүүх, цагдаад бүртгэлтэй хүмүүс;

- Цахим орчинд эрхээ хамгаалах, чадавхжуулахтай холбоотой асуудал тулгарч байгаа онцгой эрсдэлтэй хүүхэд, залуучууд;

Хөгжлийн бэрхшээлтэй, үүний дотор оюуны бэрхшээлтэй хүмүүс хуулийн болон нийтийн эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ авахдаа “системтэй” албан хүчээр харилцах шаардлагатай болж байна.

Баялаг ба нийгмийн тэгш бус байдал нь бодлогын үр дүн байдаг шиг цахим технологиудын нөлөөгөөр гаарсан тэгш бус байдал нь засгийн газар, корпорациудын зориуд гаргасан шийдвэрийн хаялга юм.²⁹ Иймээс засгийн газар, корпорациуд, түүнчлэн хүний эрхийн байгууллага, бусад оролцогч талууд тодорхой нэгдсэн стратегийн тусламжтайгаар тэгш бус байдлыг багасгах эсвэл урьдчилан сэргийлэх боломжтой.

²⁸ Amnesty International, *Surveillance giants: How the business model of Google and Facebook threatens human rights* (Index: POL 30/1404/2019); Amnesty International, *Myanmar: The social atrocity: Meta and the right to remedy for the Rohingya* (Index: ASA 16/5933/2022).

²⁹ World Inequality Lab, *World Inequality Report 2022* <https://wir2022.wid.world>, pg. 11.

4. ТЕХНОЛОГИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ АЛХАМ

**ТЕХНОЛОГИЙН БИЙ БОЛГОЖ БҮЙ ТЭГШ БҮС БАЙДАЛ НЬ БИДНИЙ
АМЬДРАЛЫН БОЛОН ЗАСАГЛАЛЫН БАРАГ БҮХ САЛБАРТ НӨЛӨӨЛЖ
БАЙГААГ ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧЛИЙГ ГААРУУЛЖ БҮЙ ГОЛЛОХ ХОЁР
САЛБАРААР ЭНЭ ТАЙЛАНД АВЧ ҮЗЭХ БОЛНО.**

1 Нэгдүгээрт, хүний эрхийн зөрчилд холбогдсон Засгийн газар, бизнесийн байгууллагууд ихэнхи тохиолдолд автоматжуулсан технологийн хэрэгсэл ашигласан бөгөөд шийдвэр гаргахдаа арьс өнгө, үндэс угсаа, эдийн засаг, жендэр, бусад хэлбэрээр ялгаварлан гадуурхах нөхцөл бүрдүүлж байгааг Эмнести Интернэшнлийн судалгаа нотолсон.³⁰

2 Хоёрдугаарт, ялангуяа сүүлийн 5-10 жилийн хугацаанд дэлхий дахинд хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхийн зөрчлүүд нь ялангуяа технологи, өгөгдөлд суурилсан ажлын байр, хөдөлмөрийн нөхцөл, ажил төрлийн аль алинд нь асар их нөлөөлж байгаатай холбоотой. Нийгмийн хамгаалал, халамжийн тогтолцооны төсвийн эрс таналт, хоол хүнс, орон байр, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах зэрэг хүний суурь олон эрхийг хувийн хэвшлээс хамааруулсан нь санаа зовоосон асуудал юм.

Хүний эрхийн хүчирхийлэл, зөрчлүүд олон хэлбэртэй бөгөөд технологийн салбарт харилцан хамааралтай нь ажиглагдаж байна.

Хамгийн чухал нь нийгмийн хамгаалал,³¹ эдийн засаг, соёл, нийгмийн болон бусад эрхүүд нь хоорондоо холбоотой бөгөөд Засгийн газрууд ялангуяа XXI зуунд эмзэг байдалд орсон хүмүүсийн эрхийг хангаж, шаардлага хангасан эрүүл, аюулгүй амьдрах орчинг бүрдүүлэх үүрэгтэй. Цаашилбал, хувийн нууцтай байх эрх нь ялгаварлан гадуурхахгүй байх, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрхтэй салшгүй холбоотой. Хүний эрхийн хөтөлбөр нь технологийн үүсгэсэн тэгш бус байдлын хор уршгийг арилгахад чиглэсэн бөгөөд технологид суурилсан улс төр, иргэний болон эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хамгаалах нь маш чухал. Үүнийг хэрэгжүүлэхэд технологийн тэгш байдал чухал үүрэгтэй.³²

³⁰ It is also important to note that the right to non-discrimination is a cross-cutting right, on which the enjoyment of all other rights is fundamentally based. For more, see: Committee on Economic, Social, and Cultural Rights, General Comment No. 20 (E/C.12/GC/20) 10 June 2009, <https://www2.ohchr.org/english/bodies/cescr/docs/gc/e.c.12.gc.20.doc>.

³¹ “A key factor behind the economic insecurity driving many protests is the fact that the vast majority of people simply do not enjoy their right to social security, realized through the implementation of social protection measures, in a way that would protect them from crises and precarity and support them to recover.” From Amnesty International, *Rising Prices, growing protests: the case for universal social protection* (Index: POL 40/6589/2023).

³² Michelle Gilman, Data & Society, *Expanding Frameworks: An economic justice approach to digital privacy*, November 6, 2019.

5. ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХГҮЙ ТЭГШ БАЙХ ЭРХ

ҮНДЭСЛЭЛ БА ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хүний эрхэд нөлөөлж буй технологийн үүсгэсэн тэгш бус байдлын хамгийн том нөлөөллийн нэг нь тэгш эрх болон ялгаварлан гадуурхахгүй байх эрхэд үзүүлж байгаа нөлөө юм.³³

Технологид суурилсан мэдээллийн удирдлагын систем нь Засгийн газруудын үйлдсэн арьсны өнгө, үндэс угсаа, эдийн засаг, нийгмийн ялгаварлан гадуурхалтай холбоотой нь ажиглагдсан.³⁴ Мэдээллийн удирдлагын системүүд нь зохион бүтээгчдийнхээ үзэл бодол, хүнийг ялгаварлах хандлага агуулсан мэдээллийн санг хэрэглэдэг бөгөөд ялгаварлан гадуурхалт, зөрчлийн хэлбэрүүд далд биш, хариуцлага тооцогддоггүй, дахин давтагдах магадлалтай байдаг. Цахим технологи эсвэл бүтээгдэхүүнүүд нь тухайн хүнийг урьдчилан таамагласны үндсэн дээр хувь хүний орон байртай байх, зээлийн эсвэл төрийн үйлчилгээ авах гэх мэт эдийн засаг,

нийгэм соёлын эрхүүдийг эдлүүлэх эсхүл хууль сахиулах тогтолцооны шүүн таслах хамгааллын түвшинг тогтооход ашиглагдаж байгаад хүний эрхийн мэргэжилтнүүд санаа зовнидог. Тэгш байх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмууд нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт,³⁵ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц,³⁶ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт³⁷ зэрэг олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд тусгагдсан хүний эрхийг хамгаалах үндсэн ойлголтуудын нэг юм. Эдгээр баримт бичгийн дагуу хүн бүр хуулийн дор тэгш эрхтэй бөгөөд «арьсны өнгө, жендэр, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, нийгмийн гарал үүсэл, өмч хөрөнгө, хөгжлийн бэрхшээлтэй байдал»³⁸ дээр нь үндэслэж ялгаварлан гадуурхахыг хориглосон байдаг.³⁹

ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ХУВИЙН ХЭВШЛИЙНХНИЙ ҮҮРЭГ

Олон улсын хүний эрхийн хуульд “төр, хувийн хэвшлийн түншлэл”⁴⁰ гэсэн ойлголт нь оролцогч талуудын ялгаварлан гадуурхахгүй, тэгш байх эрхийг хангахад хэрхэн оролцох тодорхой зохицуулалтыг илэрхийлдэг. Засгийн газрууд олон эрхийн гол тулгуур тэгш эрх, ялгаварлан гадуурхахгүй байх эрхийг ямагт хүндэтгэх,

хамгаалах, биелүүлэх үндсэн үүрэгтэй. Олон улсын эрх зүйн дагуу ямар ч нөхцөлд Засгийн газрууд тэр дундаа өгөгдөлд эсвэл технологид суурилсан систем зохион бүтээх, хэрэгжүүлэхдээ ялгаварлан гадуурхах, хүний эрхийг зөрчиж болзошгүй үйлдэл гаргаж болохгүй.⁴¹ Засгийн газрууд ялгаварлан гадуурхахгүй байхаас гадна,

³³ Amnesty International, *Xenophobic machines: discrimination through unregulated use of algorithms in the Dutch childcare benefits scandal* (Index: EUR 35/4686/2021), pg. 18, para. 1.

³⁴ Virginia Eubanks, Harper's Magazine, *The Digital Poorhouse*, 2018, <https://harpers.org/archive/2018/01/the-digital-poorhouse/>.

³⁵ International Covenant on Civil and Political Rights (ICCPR), Article 4, Article 24, Article 26.

³⁶ UN Convention on the Rights of Persons with Disabilities (CRPD), Article 5.

³⁷ International Covenant on Economic, Social and Cultural Rights, 1966, Article 2; International Convention on the Elimination of All Forms of Racial Discrimination, 1965, Articles 1-7; Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women, 1979, in particular: Articles 1, 2, 3, and 11.

³⁸ International Covenant on Civil and Political Rights (ICCPR), Article 26.

³⁹ UN General Assembly, *Convention on the Rights of Persons with Disabilities: resolution* / adopted by the General Assembly, 24 January 2007, A/RES/61/106.

⁴⁰ UN Guiding Principles on Business and Human Rights: Implementing the United Nations “Protect, Respect and Remedy” Framework, 2011, UN Doc HR/PUB/11/04, (Guiding Principles) www.ohchr.org/Documents/Publications/GuidingPrinciplesBusinessHR_EN.pdf.

түүнээс урьдчилан сэргийлэх, ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоох, эрх тэгш байх эрх болон бусад заавал дагаж мөрдөх ёстой хууль тогтоомжуудыг дэмжих үүрэгтэй.⁴² Мөн Засгийн газрууд өөрсдийн нутаг дэвсгэр эсвэл харьяаллын бүх аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаандаа мөрдөх хүний эрхийн хэмжээг тодорхой тогтоож өгөх ёстой.⁴³

ХУВИЙН ХЭВШИЛ ХҮНИЙ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭХ ҮҮРЭГТЭЙ. ЭНЭ НЬ ТӨРИЙН ХАРИУЦЛАГААС ТУСДАА ОЙЛГОЛТ ЮМ.⁴⁴

Энэхүү үүргээ биелүүлэхийн тулд хувийн хэвшлийнхэн үйл ажиллагааныхаа учирч болзошгүй бүхий л сөрөг нөлөөллийг үнэлэх, учирсан хохирлыг барагдуулах зэргээр хүний эрхийг хүндэтгэн сахих талаар тусгах ёстой.⁴⁵ НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмуудад (UNGPs) заасны дагуу “Компаниуд хүний эрхийн бодит, болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх, багасгах, шийдвэрлэхийн тулд үйл ажиллагаа, бизнес бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдвэр, ханган нийлүүлэлтийн сүлжээ, салбарууддаа хүний эрхийг хангах үндсэн алхмууд хийх ёстой.⁴⁶ Цахим технологи нэвтрүүлж буй хувийн хэвшлийнхэн шинэ харилцааг хөгжүүлэхдээ хүний эрхийг хамгаалах үндсэн зарчмаа нэн

даруй тодорхойлж, түүнчлэн хүмүүсийн үзэл бодол, олон талт байдлыг шинэ технологи боловсруулан, нэвтрүүлэх үйл явцдаа хангах шаардлагатай.⁴⁷ Ялангуяа машин сургалтын системийг нэвтрүүлэх, туршихдаа ялгаварлан гадуурхалтыг өөгшүүлэхээс зайлсхийж, хүний эрхийг илүү өргөн хүрээнд хүндэтгэхийн тулд хүний эрхийн журмыг дагаж мөрдөх ёстой. Энэ үйл явц нь үндсэн гурван үе шаттай:

- 1 Ялгаварлан гадуурхахад хүргэж болзошгүй үр дагаварыг тодорхойлох,**
- 2 Ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх, бууруулах үр дүнтэй хариу арга хэмжээ авах,**
- 3 Машин сургалтын систем дэх ялгаварлан гадуурхалтыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, багасгах хүчин чармайлтын ил тод байдлыг хангах.⁴⁸**

Энэ тайланд эдгээр зарчим болон технологийн бусад өргөн хүрээний хэрэглээг авч үзлээ. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн асуудлаарх хараат бус шинжээч «Ялгаварлан гадуурхах хэлбэрийг арилгахад чиглэсэн үзлийг тодорхой баримтлах нь XXI зууны хүний эрхийн ажлын гол үндэс юм» гэж тэмдэглэжээ.⁴⁹ Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг технологийн хүрээн дэх хүний эрхийн журам нь маш чухал бөгөөд аливаа цахим бүтээгдэхүүнийг боловсруулж, нэвтрүүлэх явцад тусгагдах ёстой.

⁴¹ Guiding Principles, Principle 1

⁴² Guiding Principles, Principle 3

⁴³ Guiding Principles, Principle 2

⁴⁴ Guiding Principles, Principle 2

⁴⁵ Guiding Principles, Principle 4

⁴⁶ UN Human Rights Business and Human Rights in Technology Project (B-Tech): Applying the *UN Guiding Principles on Business and Human Rights to digital technologies* – overview and scope. November 2019. https://www.ohchr.org/sites/default/files/Documents/Issues/Business/B-Tech/B_Tech_Project_revised_scoping_final.pdf.

⁴⁷ UN Human Rights Business and Human Rights in Technology Project (B-Tech): Scoping Paper, pg. 5-6.

⁴⁸ The Toronto Declaration: Protecting the right to equality and non-discrimination in machine learning systems. <https://www.torontodeclaration.org/declarationtext/english/#equality>.

⁴⁹ *Racial and Xenophobic discrimination and the use of digital technologies in border and immigration enforcement* - Report of the Special Rapporteur on contemporary forms of racism, racial discrimination, xenophobia and related intolerance, UN Doc A/74/321, pg. 2, para. 7-8.

АЛГОРИТМЫН ТЭГШ БУС БАЙДАЛ

Нийтийн ашиг тусын төлөө програм хангамж ашиглаж шийдвэр гаргадаг цахим хэрэгслүүд⁵⁰ нь нийгэм, эдийн засгийн олон төрлийн тэгш бус байдлыг технологи хэрхэн даамжруулдгийг харуулах тод жишээ юм. Дэлхий даяар Засгийн газрууд олон нийтэд хандсан үйлчилгээндээ програм хангамж ашиглаж шийдвэр гаргах нь арьсны өнгө, үндэс угсаагаар алгачилах болон бусад төрлийн ялгаварлан гадуурхалтын хэлбэрийг улам хурцатгаж байна.⁵¹ Хэдийгээр ийм тогтолцоог Засгийн газрууд нийгмийн үйлчилгээг хялбарчилж, залилан мэхлэхээс урьдчилан сэргийлэх арга гэж байнга дурддаг ч үнэн хэрэгтээ гадуурхагдсан эсвэл нийгмийн суурь үйлчилгээнээс хол бүлгүүдийн эрхийг зөрчих нь элбэг.⁵² Жишээ нь, олон хотын захиргаа, засгийн газрууд иргэдэд нийгмийн үйлчилгээ, тусламж үзүүлэхдээ хувь хүнд нь тохируулсан автоматжуулсан эсвэл машинд суурилсан шийдвэр гаргадаг хэрэгслүүд нэвтрүүлсэн ч дан эсвэл давхар гадуурхалтад өртсөн хүмүүсийн талаар дүгнэлт гаргахдаа гэмт хэргийн, санхүү, нийгмийн өндөр эрсдэлтэй хэсгийг ялгаж чаддаггүй нь нотлогджээ.⁵³ Технологи хөгжүүлэх, нэвтрүүлэх, удирдахдаа ялгаварлан гадуурхахгүй байх нь нийгмийн хамгааллын гол бүрэлдэхүүн хэсэг юм.

Нөлөөлөлд өртсөн иргэд нэн чухал үйлчилгээнд хамрагдахын тулд хувийн болон нууц мэдээллээ цахим хэлбэрээр өгөх шаардлагатай болдог ба эдгээр нууц мэдээллийг төрийн болон хувийн хэвшлийн оролцогчид, шүүх, хууль хүчний агентлаг, эрүүл мэнд, санхүүгийн байгууллагуудтай хуваалцах боломжтой юм.⁵⁴ Халамжийн цахим систем нэвтрүүлснээр улс орнууд ялгаварлан гадуурхах нөхцлийг улам нэмэгдүүлэх магадлалтай бөгөөд энэ эрсдлийг бууруулахад чиглэсэн хөндлөнгийн оролцоо нэн чухлыг НҮБ-ын Ялгаварлан гадуурхах, арьс өнгөөр алагчлах, жигших, үл тэвчих орчин үеийн хэлбэрийн асуудлаарх Тусгай илтгэгч онцолжээ.⁵⁵

ХАЛАМЖИЙН ЦАХИМ СИСТЕМ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫГ УЛАМ ДЭВЭРГЭХЭЭР БАЙНА.

⁵⁰ A set of mathematical instructions or rules that calculate an answer to a problem or question, which is then used, with or without the input of a human, to make predictions or decisions. See also: Amnesty International, *Xenophobic machines: discrimination through unregulated use of algorithms in the Dutch childcare benefits scandal* (Index: EUR 35/4686/2021).

⁵¹ Amnesty International, *Xenophobic machines: discrimination through unregulated use of algorithms in the Dutch childcare benefits scandal* (Index: EUR 35/4686/2021).

⁵² Amnesty International, *Serbia: Social Card law could harm marginalized members of society – legal opinion* (Press release, 28 November 2022).

⁵³ Amnesty International, *Xenophobic machines: discrimination through unregulated use of algorithms in the Dutch childcare benefits scandal* (Index: EUR 35/4686/2021); Amnesty International, *Serbia: Social Card law could harm marginalized members of society – legal opinion* (Press release, 28 November 2022); *Report to the General Assembly of the Special rapporteur on extreme poverty and human rights*, UN Doc. A/74/48037 (2019), para. 1.

⁵⁴ Heidi Ledford, *Millions of black people affected by racial bias in health-care algorithms*, *Nature*, 2019, <https://www.nature.com/articles/d41586-019-03228-6>.

⁵⁵ UN Special Rapporteur on contemporary forms of racism, racial discrimination, xenophobia and related intolerance, 18 June 2020, UN Doc. A/HRC/44/57, para. 42.

5.1. ТОХИОЛДОЛ СУДЛАЛ: Үзэн ядалтыг дэвэргэгч машин

Эмнести Интернэшнлийн “Xenophobic Machines” нэртэй тайланд сэтгүүлч, идэвхтэн, иргэний нийгмийн байгууллагуудаас цуглуулсан нотолгоонд үндэслэн, Нидерланд улсад хүүхэд асрах тэтгэмж олгоход ашигладаг програм хангамж нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн элемент агуулсныг илчилсэн.

НИДЕРЛАНДЫН ЗАСГИЙН ГАЗАР

**ЭНЭ СИСТЕМИЙГ АШИГЛАЖ БАГА ОРЛОГОТОЙ,
НИЙГМИЙН ЦӨӨНХ МЯНГА МЯНГАН ЭЦЭГ ЭХ,
АСРАН ХАМГААЛАГЧДАД СУУРЬ ҮЙЛЧИЛГЭЭГ
ҮЗҮҮЛЭХЭЭС ТАТГАЛЗСАН БАЙНА.**

Хүн хянахгүй бол эдгээр алгоритмын бие даан ажиглах механизм нь ялгаварлал үүсгэгч эмзэг бүлгүүдийн “эрсдэлийн” оноог нэмэгдүүлдэг. Дэлхий даяар өргөнөөр хэрэглэгддэг “хар хайрцаг” систем нь ялгаварлан гадуурхлаас хамгаалахыг зорьж буй олон хүмүүсийн санааг зовоож байна.⁵⁶ Дэлхийн олон оронд хууль сахиулах салбарт цахимчлал, алгоритмын шийдвэр гаргах хэрэглээ улам бүр нэмэгдсэнтэй холбогдуулан эрх тэгш ялгаварлан гадуурхахаас ангид орших эрхийг хангах нь маш чухал болжээ. Нийтээр нь тандах, царай таних цахимжсан систем нь арьсны өнгөөр болон үндэстний цөөнхийг ялгаварлан гадуурхах үйлдлийн хор хөнөөлт байдлыг улам нэмэгдүүлдэг болохыг судлаачид тогтоожээ. Энэ нь системийн ялгаварлан гадуурхалт мөн бөгөөд үүний нөлөөлөлд өртөж ирсэн иргэдийг зөвхөн арьс өнгө эсхүл үндэстний цөөнхийнх нь хувьд тандах, хянах эсхүл сэжиглэх боломжтой нөхцөлийг бий болгож байна.⁵⁷

Дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг үнэлэх, гэмт хэргийн урьдчилан таамаглах систем зэрэг эрүүгийн эрх зүй дэх өгөгдөл эсхүл технологид суурилсан хэрэгслүүд тодорхой бүлгүүдийн ялгаварлан гадуурхагдах нөхцөлийг бүрдүүлж байгаа бөгөөд энэ нь олон улсын эрх зүй, хүний эрхийн хэм хэмжээнд заасан эрх тэгш, ялгаварлан гадуурхалтаас ангид орших үзэл баримтлалд нийцэхгүй байна.⁵⁸

⁵⁶ Further reading: Amnesty International, *Xenophobic machines: discrimination through unregulated use of algorithms in the Dutch childcare benefits scandal* (Index: EUR 35/4686/2021).

⁵⁷ Amnesty International, Ban the Scan Petition, <https://www.amnesty.org/en/petition/ban-the-scan-petition/>.

⁵⁸ *Human Rights, Racial Equality, & New Information Technologies: Mapping the Structural Threats*. June 2020, The Promise Institute for Human Rights. <https://promiseinstitute.law.ucla.edu/wpcontent/uploads/2022/05/Human-Rights-Racial-Equality-New-IT-Report-3.pdf>.

5.2. ТОХИОЛДОЛ СУДЛАЛ: Царай таних технологи

Дэлхийн олон хотуудад царай таних технологи ашиглаж байгаа нь технологид суурилсан хэрэгслүүд тэгш бус байдлыг нэмэгдүүлж хувийн нууцад үл халдах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхүүдэд заналхийлж байгаагийн жишээ юм.

Эмнести Интернэшнл хэд хэдэн тайландаа энэхүү технологийн хэрэглээг баримтжуулсан бөгөөд “Ban The Scan” кампанит ажлын хүрээнд:

**ЦАРАЙ ТАНИХ ТЕХНОЛОГИ НЬ ЦАХИМ СҮЛЖЭЭ
ХЭРЭГЛЭДЭГ ОЛОН САЯ ХҮМҮҮСИЙН ЗҮРГИЙГ
ЗӨВШӨӨРӨЛГҮЙГЭЭР АШИГЛАН НИЙТЭЭР НЬ
ТАНДАХ СИСТЕМ ЮМ.**

Энэ дата нь дэлхийн олон оронд аюулгүйн алба, хууль сахиулах агентлагуудын системд бүртгэгдэн арьс өнгө, үндэс угсаагаар ялгаварлан гадуурхагдсан бүлгүүдэд шударга бус хандах нөхцөл бүрдүүлж байна.⁵⁹

⁵⁹ Further reading: Amnesty International, Ban the Scan Petition, <https://www.amnesty.org/en/petition/ban-the-scan-petition/>; Amnesty International, India: Hyderabad ‘on the brink of becoming a total surveillance city,’ (Press release, November 9, 2021); Amnesty International, Automated apartheid: how facial recognition fragments, segregates, and controls Palestinians in the OPT (Index: MDE 15/6701/2023).

6. ХӨДӨЛМӨРИЙН АЯТАЙ НӨХЦӨЛӨӨР ХАНГУУЛАХ ЭРХ

ҮНДЭСЛЭЛ БА ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Өнөөгийн дэлхийн тэгш бус байдлын хямрал, технологитой холбогдож байгаа нь ялгаварлан гадуурхагдсан бүлгүүд, эмэгтэйчүүд, бүтцийн тэгш бус байдал, колоничлолд өртсөн хүмүүсийн цалин хөлсөө шударгаар авч ажиллах боломжийг улам бүр хомсдууллаа.⁶⁰ Баялаг нь цөөн тооны эрх мэдэлтэй хувь хүмүүс, аж ахуйн нэгжүүдийн гарт төвлөрч харин нөгөө талд нь ажилчид нэгэн хэвийн эсвэл бага цалин хөлстэйгөөр инфляцын өсөлттэй тулгарч, хоол хүнс, орон байр, эрүүл мэндээр хангагдах эрхээ эдлэхэд улам хүнд болгож байна.⁶¹

Барилгын эсвэл биеийн хүчний, тээвэр, хүргэлтийн ажил эрхлэгчид, халамжийн бага орлоготой эсвэл тогтсон ажилгүй ажилчдын хувьд уур амьсгалын хямрал,⁶² Ковид-19 цар тахлын⁶³ нөлөө өдөр тутмын ажил амьдралд шинэ төрлийн эрсэл учруулахын зэрэгцээ урьд өмнөхөөс хүнд нөхцөл тулгаж байна. Үүний хажуугаар дэлхий даяар олон Засгийн газар ажилчдын эвлэлдэн нэгдэх,⁶⁴ бусад хэлбэрээр хамтран тэмцэх эрхийг улам бүр боогдуулж⁶⁵

тогтворгүй, аюултай хөдөлмөрийн нөхцөлд нөхөн төлбөр олголгүйгээр ажил олгогчдын шаардлагыг хүлээн авах хүмүүсийн тоог нэмэгдүүлж байна. Аюулгүй хөдөлмөрлөж шударга цалин хөлс авах эрхийг олон улсын эрх зүйн хүрээнд олон баримт бичгүүдээр хамгаалдаг. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 6-7 дугаар зүйлд зааснаар “Засгийн газрууд хувь хүний шударга, хөдөлмөрийн аятай нөхцөлд ажиллах”, тэр дундаа “адил хөдөлмөрт ижил цалин хөлс авах”,⁶⁶ түүнчлэн “аюулгүй, эрүүл хөдөлмөрийн нөхцөл” болон “амралт, чөлөөт цаг, ажлын цагийг тодорхой үндэслэлтэйгээр хязгаарлах” үүрэгтэй. Мөн дээрхи баримт бичигт бүх хүнийг “эрүүл аюулгүй орчинд амьдрах”⁶⁷ эрхийг баталгаажуулж, ажилчдын эвлэлдэн нэгдэх, ажил хаях эрхүүдийг хамгаалах ёстойг заажээ. Эдгээр хамгаалалтад нийгмийн хамгааллын эрх, нийгэм, эдийн засгийн мөлжлөгөөс хүүхэд, залуучуудыг хамгаалах, бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэнд, түүнчлэн «эрүүл аюулгүй

⁶⁰ Amnesty International, Inequality in 2018 (News story, December 2018).

⁶¹ International Labor Organization (ILO), The impact of COVID-19 and inflation on wages and purchasing power, 2022, https://www.ilo.org/global/about-the-ilo/newsroom/news/WCMS_862321/lang-en/index.htm.

⁶² Amnesty International, A burning emergency: extreme heat and the right to health in Pakistan (Index: ASA 33/6823/2023).

⁶³ Garofalo, Livia, Amanda Lenhart, Ireti Akinrinade, and Joan Mukogosi. Essentially Unprotected: Health Data and Surveillance of Essential Workers During the COVID-19 Pandemic. New York: Data & Society Research Institute, 2023. <https://dx.doi.org/10.2139/ssrn.4343045>.

⁶⁴ The New York Times, ‘Supreme Court Backs Employer in Suit over Strike Losses,’ June 6, 2023, <https://www.nytimes.com/2023/06/01/business/economy/supreme-court-strikes-teamsters.html>.

⁶⁵ ILO, ‘ITUC Global Rights Index 2022 shows that many workers in Central and Eastern Europe have no access to rights,’ July 19, 2022: https://www.ilo.org/global/docs/WCMS_851377/lang-en/index.htm.

⁶⁶ International Covenant on Economic, Social and Cultural Rights, Articles 6-7, pg. 2-3.

⁶⁷ International Covenant on Economic, Social and Cultural Rights, Articles 7-8.

орчинд хоол хүнс, хувцас хунар, орон байраар хангагдах эрх”⁶⁸ гэх мэт эрхүүдийг мөн хамруулдаг. Цаашилбал, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) Хөдөлмөрийн үндсэн зарчим, эрхийн тунхаглалд ажлын байрны эрүүл орчин,⁶⁹ аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтыг арилгах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах талаар ОУХБ-ын гишүүн оролцогчдын хүлээсэн үүрэг, амлалтыг тусгасан байдаг. Технологийн нөлөөгөөр үүссэн тэгш бус байдал нь хувийн компаниудын бодлого, шийдвэрийн үр дүн юм.

Компаниуд дэлхийн хаана үйл ажиллагаа явуулдгаас үл хамааран хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хүний эрхийг хамгаалах хариуцлага хүлээдэг.⁷⁰

НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн удирдах зарчмууд,⁷¹ Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (ЭЗХАХБ) Үндэстэн дамнасан компани удирдамж зэрэг баримт бүлгүүдэд компаниуд хүний эрхийг үйл ажиллагаандаа болон бодлогын хүрээнд хүндэтгэн, эрсдлийн үнэлгээ хийж бодит, болзошгүй нөлөөллийг шийдвэрлэж, зөрчигдсөн эрхийг сэргээх механизм бүрдүүлэх ёстойг тодорхойлсон байдаг.⁷² Корпорациудын хүний эрхийг хүндэтгэх үүрэг нь Засгийн газрын хүний эрхийн үүргээс тусдаа бөгөөд хүний эрхийг хамгаалах үндэсний хууль, тогтоомжийн хүрээнд илүү өргөн цар хүрээтэй байж болно. Корпорациудын хүний эрхийг хамгаалах, хүндэтгэх нь тэдний гаргах шийдвэрийн үндэс суурь бөгөөд хүний эрхийг хамгаалахад корпорациудын хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх нь чухал юм.⁷³

КОРПОРАЦИУДЫН ХҮНИЙ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭХ ҮҮРЭГ НЬ ЗАСГИЙН ГАЗРЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТАЛААР ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГААС ТУСДАА.

⁶⁸ ICESCR, Articles 9-11.

⁶⁹ ILO, Declaration on Fundamental Principles and Rights at Work and its Follow-up, (2022): https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_norm/---declaration/documents/normativeinstrument/. wcms_716594.pdf

⁷⁰ Under the UN Guiding Principles, “business relationships” include “relationships with business partners, entities in its value chain, and any other non-State or State entity directly linked to its business operations, products or services.

⁷¹ United Nations Guiding Principles on Business and Human Rights: Implementing the United Nations “Protect, Respect, and Remedy” Framework: 2011 (HR/PUB/11/04).

⁷² Organization for Economic Cooperation and Development (OECD), OECD Guidelines for Multinational Enterprises, 17 June 2000.

⁷³ United Nations Guiding Principles on Business and Human Rights: Implementing the United Nations “Protect, Respect, and Remedy” Framework: 2011 (HR/PUB/11/04). The UN Guiding Principles establish that to meet their corporate responsibility to respect, companies should have in place an ongoing and proactive human rights due diligence process to identify, prevent, mitigate and account for how they address their impacts on human rights. When conducting human rights due diligence, a company may identify that it may cause or contribute to – or already be causing or contributing to – a serious human rights abuse. In these cases, companies must cease or prevent the adverse human rights impacts. Where impacts are outside of the business enterprise’s control but are directly linked to their operations, products, or services through their business relationships, the UN Guiding Principles require the company to seek to mitigate the human rights impact by exercising leverage, or seek to improve leverage where leverage is limited, including through collaboration if appropriate. The responsibility to respect human rights requires companies to avoid causing or contributing to human rights abuses through their own business activities, and to address impacts in which they are involved, including by remediating any actual abuses. It also requires companies to seek to prevent or mitigate adverse human rights impacts directly linked to their operations, products, or services by their business relationships, even if they have not contributed to those impacts.

БОГИНО ХУГАЦААТ ГЭРЭЭТ АЖЛЫН СӨРӨГ НӨЛӨӨ

Технологийн салбар нь дэлхий даяарх ажлын байрны чиг хандлага, ажлын соёл, ажиллах орчинг өөрчлөхөд том үүрэг гүйцэтгэжээ.⁷⁴ Ялангуяа “богино хугацааны гэрээт ажил” буюу платформын ажлыг ихээр нэмэгдүүлж байна. Энэхүү түр ажлын зах зээл бараа бүтээгдэхүүний хүргэлт, тээвэрлэлт, унаа түрээс, аялал жуулчлал зэрэг дэлхий даяар олон чухал үйлчилгээний салбарууд хувьсан өөрчлөгдөв.⁷⁵ Түр болон бүтээгдэхүүн хүргэлтийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд хуулийн дагуу бүртгэгдээгүй болон албан бус хөдөлмөр эрхлэлтийг ашиг олох зорилгоор санал болгодог бөгөөд үүнийг үр дүнтэй, уян хатан, хүртээмжтэй байдлаар харуулахыг хичээж байна. Гэсэн хэдий ч эдгээр компани хуулийн цоорхойг ашиглан хүмүүсийг хууль бусаар түр ажиллуулснаар өрсөлдөөн ихтэй түр хугацааны хөдөлмөрийн зах зээлд найдваргүй, ажлын аюултай нөхцөл үүсгэн ажилчдын хууль ёсны хамгаалалт, нөхөн төлбөр авах боломжийг хааж байна.⁷⁶ Түр ажлын байрны зах зээл нэмэгдсээр байгаа нь одоо ашиглагддаг эсвэл шинээр гарч ирж буй технологийн

салбарын ажилчдын аюулгүй орчинд хөдөлмөрлөх эрх болон нийгмийн хамгааллын эрхийг зөрчиж байгааг олон жишээ харуулдаг.

ТҮР АЖЛЫН БАЙРНЫ ТАЛБАР ЭРЭЛТТЭЙ БАЙГААГААС АРСЬ ӨНГӨӨР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАГДСАН НИЙГМИЙН ЦӨӨНХ, ДҮРВЭГСЭД, ОРОГНОЛ ЭРЭГЧ, ГЭМТ ХЭРГИЙН БҮРТГЭЛТЭЙ БОЛОН БУСАД БҮЛГИЙН ХҮМҮҮС ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦОО СУЛ ЭНЭ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР АЖИЛЛАХ НЬ ЭЛБЭГ.

Нөлөөлөлд өртсөн хүмүүсийн тоо хангалттай цалин хөлс, хамгаалалттай бүтэн цагийн ажил эрэлхийлэлт нэмэгдсээр байгаа ч тэдэнд боломж хомс юм.⁷⁷ Энэ салбарт ажиллагсад олон төрлийн эрсдэлүүдтэй тулгардаг бөгөөд хүнд хэцүү ажлын нөхцөл, алгоритмд суурилсан бага⁷⁸ эсвэл ялгавартай⁷⁹ олгосон цалин хөлс,⁸⁰ ажлын байрны тандалтад⁸¹ суурилсан удирдлагын үйл ажиллагаа багтана. Эдгээрт⁸² бага хугацаанд их бүтээмж гаргах зорилгоор хувийн орон зайд халдах, ажлын байрны тандалт хийх, завсарлагагүй ажиллуулах гэх зэргээр эрх хязгаарлаж шийтгэсэн үйл ажиллагаа багтана.⁸³

⁷⁴ UN Department of Economic and Social Affairs, 'Digitally enabled new forms of work and policy implications for labour regulation frameworks and social protection,' September 20, 2021: <https://www.un.org/development/desa/dspd/2021/09/digitally-enabled-new-forms-of-work-and-policy-implications-for-labour-regulation-frameworks-and-social-protection-systems/>.

⁷⁵ Business & Human Rights Resource Centre, The Future of Work: Litigating Labour Relationships in the Gig Economy, March 2019: https://media.business-humanrights.org/media/documents/files/documents/CLA_Annual_Briefing-FINAL.pdf

⁷⁶ Veena Dubal, 'On Algorithmic Wage Discrimination,' January 23 2023, forthcoming in UC San Francisco Legal Studies Research Paper Series, https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=4331080; Macy L. Gray and Siddharth Suri, Ghost Work: How to Stop Silicon Valley from Building a New Global Underclass (2018).

⁷⁷ Development Centre Studies and ILO, Tackling Vulnerability in the Informal Economy, 2019: https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_protect/---protrav/---travail/documents/publication/wcms_711804.pdf.

⁷⁸ Varsha Bansal, Wired, 'Gig Workers Are Being Stabbed, Stoned, and Abused in India,' April 12, 2023: <https://www.wired.com/story/india-gig-workers-violence-deadly-attacks/>.

⁷⁹ Veena Dubal, Mishal Khan, Funda Ustek-Spilda, and Mark Graham. "Fairwork United States Ratings 2023: A Crisis of Safety and Fair Work in a Racialised Platform Economy," Fairwork, 2023, <https://fair.work/wp-content/uploads/sites/17/2023/08/Fairwork-US-Ratings-2023.pdf>.

⁸⁰ Veena Dubal, 'On Algorithmic Wage Discrimination,' January 23 2023, forthcoming in UC San Francisco Legal Studies Research Paper Series, https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=4331080.

⁸¹ Brian Callaci, Phenomenal World, 'Digital Scab, Digital Snitch,' May 28, 2020: <https://www.phenomenalworld.org/analysis/digital-scab-digital-snitch/>.

⁸² Veena Dubal, Logic Magazine, 'A Brief History of the Gig,' May 4, 2020, <https://logicmag.io/security/a-brief-history-of-the-gig/>; See also: Amnesty International, Digital platforms are wrong: we don't have to choose between workers' rights and flexibility, March 17, 2021 (News Report): <https://www.amnesty.org/en/latest/news/2021/03/uber-false-choice-between-workers-rights-and-flexibility/>.

⁸³ Alexandra Mateescu and Aiha Nguyen, Explainer: Workplace Monitoring and Surveillance, Data & Society, February 2019: https://datasociety.net/wp-content/uploads/2019/02/DS_Workplace_Monitoring_Surveillance_Explainer.pdf.

6.1. ТОХИОЛДОЛ СУДЛАЛ: ГЭРЭЭТ АЖЛЫН БАЙРНЫ ЗАХ ЗЭЭЛ

Эрсдэл учирч болзошгүй том эдийн засагтай цахим шилжилт хийж буй олон салбарын нэг бол албан ёсны бичиг баримтгүй⁸⁴ цагаач эмэгтэйчүүд бүрдүүлдэг асрах салбар юм.

Бусад богино хугацаатай гэрээт ажлын байр буюу унаа түрээслэх, хоол хүргэх зэрэг ажлын нөхцөл тааруу салбаруудад цагаачид, дүрвэгсэд, арьс үндсээр ялгаварлан гадуурхагдсан бүлгийнхэн⁸⁵ ажилладаг бөгөөд эдгээрээс асрах ажил нь хамгийн хүнд нөхцөлтөйд тооцогддог. Хүүхэд асрах, гэр цэвэрлэх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг асрах, гэрээр эрүүл мэндийн тусламж үзүүлэх гэх мэтийг багтаасан энэ салбар дэлхийн хамгийн хурдацтай хөгжиж буй, суурь үйлчилгээний⁸⁶ салбаруудын нэг төдийгүй платформ, гар утасны аппликейшн, вэбсайтаар дамжуулан улам бүр хялбар болж байна.

**СУДАЛГААНААС ҮЗЭХЭД ГЭРЭЭТ АЖЛЫН БАЙР
ТАНДАЛТ, ХЯНАЛТЫН⁸⁷ ШИНЭ ХЭЛБЭРТ
УЛАМ БҮР ӨРТӨЖ БАЙГААГ ХАРЖ БОЛОХ БА
ТОДОРХОЙ БУС ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМИЙГ
АШИГЛАЖ АЖИЛЧДЫН ЦАЛИНГ БУУРУУЛЖ
ЭСХҮЛ АЖЛЫН НӨХЦӨЛИЙГ УЛАМ ДОРДУУЛЖ
БАЙНА.**

Үүний зэрэгцээ цахим эсвэл гар утсан дээр суурилсан асрах салбарын ажлын байрны зах зээл давамгайлж байгаа нь арьс өнгө, үндэс угсаа,⁸⁸ эдийн засгийн цахим хуваагдлыг улам хурцатгаж болзошгүй. Учир нь цахим боловсролгүй эсвэл ашиглах боломжгүй ажилчдын боломж улам багасах магадлалтай.⁸⁹

⁸⁴ National Domestic Workers Alliance (NDWA), Home Economics: The Invisible and Unregulated World of Domestic Work. New York: NDWA (2012), <https://www.domesticworkers.org/reports-andpublications/home-economics-the-invisible-and-unregulated-world-of-domestic-work/>.

⁸⁵ Julia Ticona, Alexandra Mateescu, and Alex Rosenblat, Beyond Disruption: How Tech Shapes Labor Across Domestic Work & Ridehailing, Data & Society (2018), <https://datasociety.net/library/beyond-disruption/>.

⁸⁶ Julia Ticona and Alexandra Mateescu, "Trusted strangers: Carework platforms' cultural entrepreneurship in the on-demand economy," New Media & Society (2018). <https://journals.sagepub.com/eprint/hVMJZPYsYP8sBkgwzaQk/full>.

⁸⁷ Alexandra Mateescu, "Electronic Visit Verification: The Weight of Surveillance and the Fracturing of Care" (November 16, 2021), <http://dx.doi.org/10.2139/ssrn.4181895>.

⁸⁸ Julia Ticona, "Opinion: There's an app for wrecking nannies' lives," New York Times (2018), <https://www.nytimes.com/2018/07/12/opinion/gig-economy-domestic-workers-uber.html>.

⁸⁹ Julia Ticona and Alexandra Mateescu, "Trusted strangers," (2018).

6.2. ТОХИОЛДОЛ СУДЛАЛ: ТЕХНОЛОГИЙН САЛБАРЫН «АЖИЛЧИД»

Технологийн салбарын бүтээгдэхүүн, ажлын байрны нөхцөл нь хүний эрхийг зөрчиж эдийн засаг, үндэс угсаа, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхаж, тэгш бус байдлыг үүсгэж тогтворгүй, байдлыг улам өөгшүүлдэг.

ТЕХНОЛОГИЙН САЛБАР ДАХЬ «СҮҮДРИЙН АЖИЛ» ГЭЖ ҮЛ ҮЗЭГДЭХ БҮЮУ НУУЦЛАГДСАН ДАЛД ХӨДӨЛМӨРИЙГ ХЭЛДЭГ. ЭНЭ НЬ ИХЭНХДЭЭ –ТЕХНОЛОГИЙН САЛБАР АЖЛЫН БАЙРАНД ХАМГААЛАЛТ БАГАТАЙ, ЭМЗЭГ БҮЛГИЙН ХҮМҮҮСИЙГ АЖИЛЛУУЛЖ БАЙГААГИЙН ИЛРЭЛ МӨН.

Дэлхий даяар олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, технологийн компаниудын ханган нийлүүлэлтийн сүлжээнд “арын алба”⁹⁰ гэж нэрлэгддэг зураг ялгах, контент сайжруулах зэрэг технологийн бүтээгдэхүүний үйл ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэдэг хүмүүсийн хөдөлмөрийг мөлжиж, хөдөлмөрийн тэгш бус байдлыг хурцатгаж байна. Хөдөлмөрийн хууль, тогтоомжийн эрх зүйн орчин султай улс орнуудад гуравдагч талын гэрээт ажилчдыг ихээр ажиллуулдаг “Цахим ажил”⁹¹ гэж нэрлэгддэг техникийн бүтээгдэхүүнийг сургах, удирддаг ажилчид ихэвчлэн маш бага цалин хөлстэй бөгөөд хэвлэл мэдээллийн платформуудын олон нийтийн стандартыг зөрчсөн хор хөнөөлтэй контентыг зохицуулж, хянадаг ажилчдын сэтгэцийн эрүүл мэндэд ноцтой эрсдэлийг⁹² учруулдаг. Түр ажлын байрны зах зээлийн нөлөөг судлаж үзэхэд түр ажлын байр санал болгодог бизнесийн байгууллагууд хууль зөрчсөн ч хуулийн хариуцлага, нөхөн төлбөр төлөлгүй асар их ашиг олж байна. Эдгээр компани ажилчдад тэгш цалин хөлс өгөх, шударга цалин, хөдөлмөрийн аюулгүй нөхцөлөөр хангах зэрэг хүний эрхийг хамгаалах үүргээсээ зориудаар зайлсхийдэг юм. Эцэст нь, дэлхийн өнцөг булан бүрд хиймэл оюун ухааны хэрэглээ нэмэгдэхийн хэрээр хувийн хэвслүүд түр ажиллаж байгаа ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, ажилчдын эрхийг зөрчиж, цаашлаад ажлын байрыг нь хүртэл цомхотгох эрсдэлүүд нэмэгдэж байна.⁹³

⁹⁰ Macy L. Gray and Siddharth Suri, *Ghost Work: How to Stop Silicon Valley from Building a New Global Underclass* (2018).

⁹¹ Phil Jones, ‘Big tech’s push for automation hides the grim reality of microwork,’ *The Guardian*, October 27, 2021: <https://www.theguardian.com/commentisfree/2021/oct/27/big-techs-push-forautomation-hides-the-grim-reality-of-microwork>.

⁹² Billy Perrigo, ‘Exclusive: OpenAI used Kenyan workers on less than \$2 per hour to make ChatGPT less toxic,’ *Time*, January 18, 2023: <https://time.com/6247678/openai-chatgpt-kenya-workers/>.

⁹³ Ben J. Edwards, ‘IBM Plans to replace 7,800 jobs with AI over time, pauses hiring certain positions,’ May 2, 2023: <https://arstechnica.com/information-technology/2023/05/ibm-pauses-hiring-around-7800-roles-that-could-be-replaced-by-ai/>.

6.3. ТОМ ТЕХНОЛОГИЙН АГУУЛГА САЙЖРУУЛАГЧИД

Технологи, тэгш бус байдал, хөдөлмөр хэрхэн огтлолцдогийн тод жишээ нь томоохон технологийн компаниудын контент зохицуулалт гүйцэтгэж буй ажилчид, ажлын байрны нөхцөл юм. Контент зохицуулалт нь олон технологийн платформын бизнесийн асар том загвар бөгөөд платформын үйлчилгээний нөхцөлийг зөрчсөн контентыг илрүүлэн устгаж, хэрэглэгчид хүчирхийлэлтэй, доромжилсон контент үзэхээс сэргийлдэг. Хэрвээ контент нь тухайн улсын хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд компанийг хуулийн хариуцлагаас хамгаалдаг. Ерөнхийдөө хяналт зайлшгүй шаардлагатай олон компаниуд, жишээ нь Мета цалин багатай, хууль эрх зүйн хамгаалалт муутай улс орнуудаас сонгон гуравдагч талын компаниудтай гэрээ байгуулдаг нь тухайн улсдаа харьцангуй тогтвортой ажлын байранд тооцогдох тохиолдол бий.

**СУДАЛГААНУУДАД АЖИГЛАГДАЖ БАЙГААЧЛАН
КОНТЕНТ ЗОХИЦУУЛАЛТЫН ХӨДӨЛМӨР НЬ
АЖИЛЧДЫГ УДААН ХУГАЦААНД СЭТГЭЦИЙН
ӨӨРЧЛӨЛТӨД ОРУУЛДАГ БӨГӨӨД
ИХЭНХ НЬ БАГА ЦАЛИНТАЙ АЖЛЫН БАЙРНЫ
МӨЛЖЛӨГ, ШИЙТГЭЛТЭЙ ТУЛГАРДАГ.**

Контентын зохицуулалт нь томоохон технологийн компаниудын бизнесийн загварын гол түлхүүр бөгөөд корпорациуд зах зээлийн үнэлгээгээ нэмэхийн тулд ажилчдыг системтэйгээр мөлжиж байна. Энэ нь технологи тэгш бус байдлыг бүрдүүлж, улам хурцатгадгийн тодорхой жишээ мөн.⁹⁴

⁹⁴ For more, see: Billy Perrigo, "Under Fire, Facebook's 'Ethical' Outsourcing Partner Quits Content Moderation Work," Time, January 10, 2023: <https://time.com/6246018/facebook-sama-quits-contentmoderation/>, and Caroline Kimeu, "'A watershed': Meta ordered to offer mental health care to moderators in Kenya," The Guardian, June 7, 2023: <https://www.theguardian.com/global-development/2023/jun/07/a-watershed-meta-ordered-to-offer-mental-health-care-to-moderators-in-kenya>.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАГДАХГҮЙ БАЙХ, ХУВИЙН НУУЦТАЙ БАЙХ, ХӨДӨЛМӨРИЙН АЯТАЙ НӨХЦӨЛӨӨР ХАНГАГДАХ

Ялгаварлан гадуурхагдахгүй байх, хувийн нууцтай байх, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангагдах. Хөдөлмөрийн болон ажлын байрны шударга ёс нь ялгаварлан гадуурхагдахгүй байх, хувийн нууцтай байх эрхүүд юм.

Тухайлбал, хөдөлмөрийн зах зээл дэх олон төрлийн технологийн хэрэгсэл⁹⁵ нь ажилд авах, сонгон шалгаруулалт хийх явцдаа ялгаварлан гадуурхах үйлдэл гаргадгийг тогтоосон. Ажил олгогчид зорилтод ажилд горилогчдыг сонгохдоо програм хангамжийн үнэлгээнд тулгуурлан шийдвэрээ гаргах нь нэмэгдсээр л байгаагийн зэрэгцээ цахимд суурилсан өргөдөл хүлээн авахын хэрээр эдгээр хэрэгсэл нь ажлын байранд гадуурхалтад өртөх эрсдэлтэй бүлгүүдийг ялгаварлаж байна. Эдгээр бүлэгт арьс өнгө, үндэс угсаагаараа ялгаатай хүмүүс, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийнхэн багтана.⁹⁶ Нэмж дурдахад, технологид суурилсан эсвэл автоматжуулсан ажлын байрны менежментийн хэрэгслүүд нэмэгдсэн нь хөдөө аж ахуйн салбарын⁹⁷ цагаачид, жолооч, хүргэлт, агуулахын болон бусад ажилчдад шинэ төрлийн эрсдэл бий болгож байна.⁹⁸

Технологид суурилсан хөдөлмөрийн менежмент, удирдлагын янз бүрийн хэлбэрүүд нь ажил олгогчдод давуу байдал үүсгэж ажилчдад тогтмол бус цалин өгөх, эсвэл ажлын байрны аюулгүй байдлыг алдагдуулах, шийтгэх зэргээр шахалт

үзүүлэх боломж олгодог.⁹⁹ Технологид суурилсан албан, албан бус эдийн засгийн олон салбарын менежментийн хэрэгслүүд нь ажил олгогчдод ажилчдыг маш хялбар байдлаар хянах, удирдах, шийтгэх боломж олгодог бөгөөд тэд улам эсэргүүцэл багатай, дуулгавартай болдог. Алгоритмд суурилсан эдгээр хэрэгсэл ажилчдын хувьд ноцтой үр дагаварт хүргэж цалинг тохируулах, урамшуулах, нэмэгдэл олгох, ажилд авах эсвэл халах гэх мэт чухал шийдвэрүүдэд ашиглагддаг.¹⁰⁰

АЛГОРИТМД СУУРИЛСАН ТЕХНОЛОГИ НЬ АЖИЛ ОЛГОГЧДОД АЖИЛЧДЫГ ХЯНАХ, УДИРДАХ, ШИЙТГЭХ БОЛОМЖ ОЛГОДОГ

Технологид суурилсан ажлын байрны хяналтын хэрэгслүүд нь цуглуулсан өрөөсгөл мэдээлэл дээрээ үндэслэн шийдвэр гаргадаг бөгөөд энэ нь гадуурхалтанд хэдийн өртсөн эмзэг бүлгийн ажилчдыг бодитойгоор ялгаварлан гадуурхалд дахин өртөхөд хүргэж байна.

Цахим эсвэл алгоритмд суурилсан удирдлагын хэрэгслүүд нэмэгдсэн өнөө үед хувийн нууцыг хамгаалах¹⁰¹ нь хүний хөдөлмөр урьд өмнөхөөсөө илүү шаардагдсан салбаруудын ажлын байрны орчинг сайжруулах үндэс болно.¹⁰²

⁹⁵ Khari Johnson, "Feds warn employers against discriminatory hiring algorithms", Wired, 2022, <https://www.wired.com/story/ai-hiring-bias-doj-eccc-guidance/>.

⁹⁶ Natalie Florence and Heather Ross, "How tech can make it excruciatingly hard to apply for a job while homeless", Slate, 2023, <https://slate.com/technology/2023/06/job-application-homelessnessdigital-divide.html>.

⁹⁷ Chris Ramsaroop, Reality Check 101: Rethinking the impact of automation and surveillance on farm workers, Data & Society: Points, Medium (2019): <https://points.datasociety.net/reality-check-101-c6e501c3b9a3>.

⁹⁸ Livia Garofalo, Amanda Lenhart, Joan Mukogosi, and Iretiolu Akinrinade. Essentially Unprotected: Health Data and Surveillance of Essential Workers During the COVID-19 Pandemic. Data & Society Research Institute, 2023. <https://dx.doi.org/10.2139/ssrn.4343045>.

⁹⁹ Chris Ramsaroop, Reality Check 101: Rethinking the impact of automation and surveillance on farm workers, Data & Society: Points, Medium (2019): <https://points.datasociety.net/reality-check-101-c6e501c3b9a3>.

¹⁰⁰ WorkRise Network, Jessica Shakesprere and Batia Katz, "If left unchecked, algorithmic decisionmaking could perpetuate workplace bias and harms", 2021, <https://www.workrisenetwork.org/workingknowledge/if-left-unchecked-algorithmic-decisionmaking-could-perpetuate-workplace-bias-and>.

ЖИШЭЭ НЬ, АЛГОРИТМД СҮҮРИЛЖ АЖИЛД АВАХ ХЭРЭГСЛҮҮД НЬ АЖИЛТНЫ ТУХАЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛЖ, ХУВААЛЦДАГ БӨГӨӨД ИНГЭСНЭЭР ТЭДНИЙ ХУВИЙН НУУЦТАЙ БАЙХ ЭРХИЙГ ЗӨРЧИХӨӨС ГАДНА ТУХАЙН АЖЛЫН БАЙРАН ДАХЬ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫГ ҮҮСГЭХ БОЛОМЖТОЙ.¹⁰³

Үүний зэрэгцээ ажлын байрны удирдлагын программ хангамж, тухайлбал биометрик, эрүүл мэндийн мэдээллийг автоматаар цуглуулах, алсаас хянах, урьдчилан таамаглах, тэмдэглэгээ хийх зэрэг нь хувийн нууцыг хамгаалах эрхийг зөрчиж байна.¹⁰⁴ Өгөгдөл цуглуулах, өгөгдлийн удирдлагын системээс татгалзах эрх багатай эсвэл огт байхгүй улирлын эсвэл цалин хөлс багатай ажилчдад энэхүү систем нь илүү нөлөөлж байгаа нь үнэхээр санаа зовоож буй асуудал мөн.¹⁰⁵

Ялгаварлан гадуурхалттай, хувийн нууцад халддаг, шударга бус ажлын байрны жишээ бол зах зээлд давамгайл худалдаа, хүргэлтийн үйлчилгээний Амазон компанийн ханган нийлүүлэлтийн сүлжээ юм. Зөвхөн

АНУ-д нэг сая гаруй хүн, олон улсад бие даасан гэрээт гүйцэтгэгч гэж ангилагддаг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, илүү цагийн хөлс, ажлын байрны хамгаалалт авах эрхгүй 2.9 сая «гэрээт жолооч» ажиллаж байна.¹⁰⁶ Амазон компани нь ажлын байран дахь хяналтын шинэ төрлийн технологи нэвтрүүлэх чиглэлээр тэргүүлснээр хяналтын камер зүүлгэх, гар утсанд хянах төхөөрөмж суурилуулах, хөдөлгөөн мэдрэгчийг ажлын байранд ашиглах байдлаар ажилтнуудын¹⁰⁷ эрүүл мэндэд эрсдэл учруулж болох хяналтын техник хэрэгслүүд ашиглаж байна.¹⁰⁸ Жишээлбэл, Амазоны томоохон агуулахуудын нэг Миннесотагийн «түгээлтийн төв»-ийн ихэнхэд Сомали-Америкийн оршин суугчид ажилладаг бөгөөд “ажлын завсарлага”¹⁰⁹ гэж нэрлэсэн тандалттай төстэй удирдлагын систем тэдний амрах, эмчлүүлэх эрхийг зөрчиж байна. Ажилчдын ихэнх нь гэгдэх дүрвэгсдэд эх хэлээр нь ажлын байрны сургалт явуулдаггүй, ажлын байрны техник хэрэгслүүд нь мэдэхгүй хэл дээр бичигдсэн, дэлхий даяар муслим шашинтнуудын тэмдэглэдэг амралтын өдрүүдэд амралт өгөхгүй байх зэргээр ялгаварлан гадуурхаж байна.¹¹⁰ Технологид суурилсан ажлын байран дахь хүний эрхийн зөрчлийг зогсоохын тулд гадуурхагдсан бүлгүүд хамтдаа тэмцэн технологийн тэгш байдлыг халах ёстой.

¹⁰¹ This right is guaranteed under several international human rights instruments, including Article 17 of the ICCPR, which protects individuals from “arbitrary or unlawful interference” in privacy, the family, home, or correspondence, as well as from “unlawful attacks on [their] honour and reputation.” The United Nations, Amnesty International, and other human rights organizations have repeatedly demonstrated how this core right is increasingly fundamental to a series of interrelated rights for individuals in the digital age, to the extent that the right to privacy is, in fact, “a foundational right,” particularly in an era in which the sharing and tracking of personal data is a growing part of everyday life. The ICCPR also makes clear that the right to privacy applies to everyone, and that difference in its protection on the basis of “race, colour, language, religion, political or other opinion, national or social origin, property, birth or other status” is inconsistent with the principles of non-discrimination and equality (ICCPR, Article 17).

¹⁰² Angela Chen, ‘Inmates in Finland are training AI as part of prison labor: empowerment or exploitation?’ The Verge, March 28, 2019: <https://www.theverge.com/2019/3/28/18285572/prison-labor-finland-artificial-intelligence-data-tagging-vainu>.

¹⁰³ Javier Sánchez-Monedero and Lina Dencik, The datafication of the workplace, Data Justice Lab, May 9, 2019: <https://datajusticeproject.net/wp-content/uploads/sites/30/2019/05/Report-The-datafication-of-the-workplace.pdf>

¹⁰⁴ See, for example: Aiha Nguyen, The Constant Boss: Work Under Digital Surveillance, Data & Society, 2021, and Managed By Bots: Data-Driven Exploitation in the Gig Economy, Worker Info Exchange, 2021.

¹⁰⁵ Alexandra Mateescu and Aiha Nguyen, ‘Explainer: workplace monitoring & surveillance,’ Data & Society, February 6, 2019: <https://datasociety.net/library/explainer-workplace-monitoring-surveillance/>.

¹⁰⁶ Sandeep Vaheesan, “The shadow empire that fuels Amazon’s dominance,” The New Republic (2023): <https://newrepublic.com/article/170708/contracts-surveillance-amazon-anti-trust>.

¹⁰⁷ Brishen Rodgers, “Workplace data is a tool of class warfare,” Boston Review (2023): <https://www.bostonreview.net/articles/workplace-data-is-a-tool-of-class-warfare/>.

¹⁰⁸ Lauren Kaori Gurley, “Amazon delivery drivers say they sacrifice their safety to meet holiday rush,” Vice News (2021): <https://www.vice.com/en/article/5dg3wb/amazon-delivery-drivers-say-they-sacrificetheir-safety-to-meet-holiday-rush>

¹⁰⁹ Erica Hellerstein, “How Somali workers are fighting Amazon’s surveillance machine,” Coda Story (2023):

¹¹⁰ Maximilian Alvarez, “Warehouse workers in Minnesota took on Amazon and won”: interview with Khali Jama, The Real News Podcast (2023): <https://therealnews.com/how-immigrant-warehouse-workers-in-minnesota-took-on-amazon-and-won>

7. ДҮГНЭЛТ: ТЕХНОЛОГИЙН ТЭГШ БАЙДАЛ ХАНГАХЫН ТӨЛӨӨ

ТЕХНОЛОГИ, ТҮҮНИЙ САНХҮҮ, ЭРХ МЭДЛИЙН ТОГТОЛЦОО НЬ ХҮНИЙ ЭРХИЙН СИСТЕМЧИЛСЭН ДАЛД ЗӨРЧИЛ ҮҮСГЭЖ БАЙНА

Технологи, түүний санхүү, эрх мэдлийн тогтолцоо хүний эрхийн системчилсэн далд зөрчлийн гол өдөөгч болж байна.

Засгийн газар, компани, иргэний нийгмийн төлөөллүүд технологийн салбарын тэгш бус байдлын аюулыг багасгах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.

Нийгмийн амьдралын өргөн хүрээн дэх технологийн эрчимтэй хэрэглээ арьс өнгө, эдийн засаг, тэгш бус байдлын харилцан хамааралтай хэлбэрүүдээр хурдацтай өсөх нь хүний эрхийн байгууллагын хувьд анхаарал хандуулах ёстой хэрэг мөн.

Энэ тайлан технологид суурилсан тэгш бус байдал хүний эрхийг зөрчиж буй арга замыг өргөн хүрээнд баримтжуулах цувралын эхнийх бөгөөд хор уршгаас урьдчилан сэргийлэх, бууруулахад хувь нэмрээ оруулахыг Засгийн газар, олон нийт, компаниудад хандан Эмнести Интернэшнлээс уриалж байна.

**ЗАСГИЙН ГАЗАР, ХУВИЙН ХЭВШИЛ,
НИЙГМИЙН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ЭДГЭЭР
ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ,
БУУРУУЛАХАД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛАХЫГ
ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ УРИАЛЖ БАЙНА.**

**ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ БОЛ
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨХ
ДАЯН ДЭЛХИЙН ХӨДӨЛГӨӨН.**



976 7000-4705



www.amnesty.mn



Amnesty International Mongolia -
Монголын Эмнести Интернэшнл



members@amnesty.mn



Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Их сургуулийн гудамж,
#АВ центрийн 7 давхарт 701 тоот

**ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ**

